



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, 8 нэрийн, нийт 28,164,266.00 (хорин найман сая нэг зуун жаран дөрвөн мянга хоёр зуун жаран зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ний
өдрийн 132 дугаар тогтоолын хавсралт

"ДБҮЭГ" ТӨҮГ-ын балансаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын балансд шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Марк	Тоо шир хэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хөрөнгийн үнэ (төгрөгөөр)
1	Дууны хувиарлагч	1×10 Broadcast Standard Audio Distributor	2	2,140,920.00	4,281,840.0
2	Орчуулагчийн чихэвч	Interpreter headset	16	351,120.00	5,617,920.0
3	Чанга яригчийн хөл	Speaker tripod	2	93,873.00	187,746.0
4	Сүлжээний свич	Gigabit Network switcher	1	80,000.00	80,000.0
5	Тайзны чанга яригч	monitor and apron stage speakers	2	230,000.00	460,000.0
7	Проектор	HD color projector	2	3,321,660.00	6,643,320.0
9	Хурлын камер	HD	1	9400440	9,400,440.0
10	Микрофон wireless	Wireless handheld microphone	1	1,493,000.00	1,493,000.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		27 (хорин долоо)		28,164,266.00 (хорин найман сая нэг зуун жаран дөрвөн мянга хоёр зуун жаран зургаан)